

**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭГ
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Д/д	Хийж хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжилтийн үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
1.	Байгууллагын дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх 2022 оны төлөвлөгөөний төсөл боловсруулж батлуулах.	2022.02.15-2022.02.25	Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг үндэслэн Байгууллагын дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх 2022 оны төлөвлөгөө боловсруулан газрын даргаар 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөр батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100%
2.	Байгууллагын дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх Ажлын хэсгийн зохион байгуулах ажлын “Удирдамж” боловсруулж батлуулах, хяналт шалгалтын бэлтгэл ажил хангах.	Тухай бүр	Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа болон цаг үеийн асуудлууд, бусад ажлын хүрээнд дотоод хяналт шалгалт хийх ажлын Удирдамжийг тухай бүр газрын даргаар батлуулан гишүүдэд танилцуулж удирдамжийн хүрээнд хяналт, шалгалтыг зохион байгуулан ажилласан.	100%
3.	Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын чиглэлээр байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангуулсан эсэх, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд дүгнэлт гаргах.	II, IV улиралд	Нийт албан хаагчдад ХАБЭА-н ерөнхий ойлголт, урьдчилсан зааварчилгаа талаар, сургалтыг 2 удаа зохион байгуулж ажилласан. Шинээр ажилд орсон ажилтан, үйлдвэрийн сургалт, дадлага хийхээр ирсэн оюутан, нийт ажилтан албан хаагчид тэдний ажилласан жил, боловсролын түвшинг үл харгалзан ХАБЭА -ын зааварчилгыг урьдчилсан, анхан, давтан гэсэн 3 шатны зааварчилгааг өгч оператор техникчийг хэмжилт хийх үед, оффисын мэргэжилтэнүүд, хяналт зохицуулалтын ажилтануудад хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, сургалт хийн, журнал хөтлөсөн. Оператор техникчийг хэмжилт хийх үед хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, хангамжийн материалын хэрэгцээг тодорхойлсон. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан байгууллагын нийт албан хаагчдаас санал авч, газрын даргын 2022 оны А/06 дугаар тушаалаар байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн батлуулж албан хаагчдын нийгмийн баталгааг хангах болон тэтгэмж, дэмжлэг тусламжийн мөнгөн дүнг бага хэмжээгээр нэмэгдүүлэн олгохоор тусгасан.	100%

4	Байгууллагын төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт ажлын чиг үүрэгт нийцэж буй эсэх, ажлын байрны баталгаанд эрсдэлийн үнэлгээ хийх.	IV улиралд	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор сууршилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлэх ажлын хүрээнд сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн зургаа дугаар бүлэгт заасан Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журмыг баримтлан өөрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн төвшингээр шалгаруулах замаар нөхөн томилгоог хийсэн байна. Гүйцэтгэх ажилтны 9 сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 1/288 дугаар албан бичгээр хүргүүлэн тусгай сонгон шалгаруулалтыг хийлгүүлэхээр захиалга өгч, сул орон тоог хуулийн дагуу бүрэн нөхөж ажилласан. Сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан дагуу хуулийн хугацаанд нь Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлд албан бичгээр тухай бүрт, (csc.gov.mn) болон (www.aprd.ub.gov.mn) сул орон тоог нийтэд мэдээлэн, сонгон шалгаруулалтыг зарлуулсан.	100%
5	Байгууллагад бүртгэлтэй түлш хадгалах агуулах байрны ашиглалтад эрсдэлийн үнэлгээ хийх.	I, IV улиралд	Нийслэлийн 7 дүүргийн гэр хорооллын 203,683 айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлын хүрээнд нийслэлийн өмчийн 4 агуулах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 55 агуулахад нийт 120,000 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэн тээвэрлэлт болон урамшууллын зардалд 23 тэрбум, төгрөгийг 2022 онд олгон хяналт тавин ажилласан. Төлөвлөгөөт хяналт шалтгалын хүрээнд 2 удаагийн удирдамж боловсруулан гэрээт албан хаагч буюу диспетчерүүдийн ажлын байрны цаг ашиглалт, ажил гүйцэтгэл болон ёс зүй, зан харилцаа мөн сайжруулсан шахмал түлш хадгалах, нөөцлөх Хангамжийн бааз, агуулахууд, түлш борлуулах цэгүүдийн үйл ажиллагаанд байгууллагын Дотоод хяналтын ажлын хэсэг хяналт тавин ажилласан.	100%
6	Агаарын чанарын хэмжилт, судалгааны суурин харуулуудын тоног төхөөрөмжийн ашиглалтад эрсдэлийн үнэлгээ хийх.	II, IV улиралд	Суурин харуулуудын хэвийн ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгууллаа. Хяналт шалгалтаар лабораторийн ажлын байр, суурин харуулын үйл ажиллагаа, шинээр авсан лабораторийн газрын байдал, хэмжилтийн тоног төхөөрөмжийн ашиглалт, ажиллагааны байдалд дүн шинжилгээ хийж Чанарын гарын авлага (ЧГА), бодлого, журам, ажлын заавар, маягт, бүртгэл, сорилтын тайлан, бусад баримт бичгийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.	100%
7	НАБТГ-ын лабораторийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалт хийх.	III улиралд	Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын орчны агаарын чанарын хэмжих суурин харуулын тоног төхөөрөмжийн ашиглалт, лабораторийн үйл ажиллагааны байдалд байгууллагын дотоод хяналтын ажлын хэсгээс хяналт тавих зорилгоор 2022 оны 12 дугаар сард	100%

			лабораторийн үйл ажиллагаа, Суурин харуулуудын хэвийн ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгууллаа. Дотоод хяналт шалгалтаар лабораторийн ажлын байр, суурин харуулын үйл ажиллагаа, шинээр авсан лабораторийн газрын байдал, хэмжилтийн тоног төхөөрөмжийн ашиглалт, ажиллагааны байдалд дүн шинжилгээ хийж Чанарын гарын авлага (ЧГА), бодлого, журам, ажлын заавар, маягт, бүртгэл, сорилтын тайлан, бусад баримт бичгийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.	
8	Агаарын чанарын төлбөрт хэмжилтээс олж буй орлого төвлөрүүлэлтэд хяналт, шалгалт хийх.	II, IV улиралд	Агаарын чанарын хяналт зохион байгуулалтын хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтын ажлын хүрээнд хэмжилтийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавьж ажилласан. 2022 оны тайлант хугацаанд нийт сайжруулсан түлшний 70 дээжид хаягдал утааны хэмжилт хийж дүнг боловсруулж, Монгол Улсын MNS 5216:2016 стандартыг баримтлан заасан үзүүлэлттэй тус тус харьцуулан холбогдох албан байгууллага ААНБ-д хүргүүлсэн бол ийслэлийн төвийн зургаан кВт-аас дээш уурын болон усан халаалтын зуух эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын нийт 36 зууханд хэмжилт хийж ААНБ-д хэмжилтийн дүнг хүргүүлж, нийслэлийн төсөвт 4,2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.	100%
9	Байгууллагын өмчийн бүртгэл, тооцоо, ашиглалт, хамгаалалт, хадгалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах.	II, IV улиралд	Эд хөрөнгийн тооллого хийх комиссын гишүүд хагас, бүтэн жилээр эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг санхүүгийн программ дах байгууллагын дансанд бүртгэлтэй 615 нэр төрлийн 183,158 ширхэг нийт 9,222,213,695.28 (есөн тэрбум хоёр зуун хорин хоёр сая хоёр зуун арван гурван мянга зургаан зуун ерэн таван төгрөг хорин найман мөнгө) үндсэн хөрөнгө, хангамжийн хөрөнгийг бүртгэлтэй тулган эд хариуцагч нарыг байлцуулан албан хаагчдын хөрөнгийн тооллогыг хийсэн. Үүнд: Үндсэн хөрөнгө – 308 нэр төрлийн 180,822 ширхэг нийт 9,010,069,694 (есөн тэрбум арван сая жаран есөн мянга зургаан зуун ерэн дөрөв) төгрөг, Хангамжийн хөрөнгө – 307 нэр төрлийн 2,336 ширхэг нийт 212,144,001.28 (хоёр зуун арван хоёр сая нэг зуун нэг төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн хөрөнгө тоологдсон байна. Тооллогын явцад албан ажлын хэрэгцээнд дахин ашиглах боломжгүй болсон эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн жагсаалтыг гаргаж байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлд хүргүүлж, эргэлтийн хөрөнгийг газрын даргын тушаалын дагуу бүртгэлээс хасуулахаар болсон.	100%
10	Байгууллагын үйл ажиллагаа, төлөвлөлт, тооцоололд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.	Жилдээ	Байгууллагын 2022 онд үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 бүлэг 42 арга хэмжээг төлөвлөн 96,8 %-тай биелэлтийг ханган ажилласан. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг “Алсын хараа 2050” МУ-ын урт	100%

			хугацааны хөгжлийн баримт бичиг, Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл /2021-2025/ зэрэг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилттой уялдуудан төлөвлөж Хот төлөвлөлт судалгааны институтэд хүргүүлсэн.	
11	Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын биелэлтийг тухай бүрт илтгэх хуудсаар тайлагнаж, үйл ажиллагааны зөрчил, дутагдал арилгах.	Тухай бүрт	Байгууллагын дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх 2022 оны төлөвлөгөөний дагуу тухай бүрт удирдамж боловсруулан ажилласан бөгөөд мэдээ тайланг тогтмол газрын даргад танилцуулж ажилласан.	100%

ХЯНАСАН:
 ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
 ТАЙЛАН БИЧСЭН:
 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ХАМТЫН
 АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



О.АЛТАНГЭРЭЛ

Т.ЭНХМАА